



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/239

Бат-Өлзий сум

Шууд гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны төсвийн тодотгол батлах тухай” 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 22/01 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтын тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын хөрөнгө оруулалтаар хийгдэх Төвхөн хийд, Хойд агуйт, Бөхөн шар, Өвтийн 20000 ширхэг хуш мод будах ажлыг “Их сумт хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай шууд худалдан авах гэрээгээр гүйцэтгүүлсүгэй.

2.“Их сумт хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, Төвхөн хийд, Хойд агуйт, Бөхөн шар, Өвтийн 20000 ширхэг хуш мод будах ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.“Их сумт хайрхан” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай ажилд шаардагдах 8,000,000 (найман сая) төгрөгийг гэрээнд заасны дагуу Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

